

Төсөл: О.Байгалмаа

Санал дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дорнод аймгийн Соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтиг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА**Л.ХИШИГТОГТОХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ
19 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх
19.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл. Хурлын тогтоол

25.1.Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр

15.2.Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

14 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, түүний хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлж, хяналт тавина.

АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР /2018 – 2021 он/

I БҮЛЭГ.

1.1. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл

Монгол улсын Төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Мянганы Хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, 2030 он хүртэлх төсөөлөл”, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэн аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийн дэмжих дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

1.2. Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Дорнод аймаг нь Халх, Буриад, Барга, Үзэмчин ястны давтагдашгүй өв соёлын өлгий нутаг юм.

Өнөөдөр Дорнод аймагт улсын болон аймгийн хамгаалалттай нийт 193 үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 178 хүн үүнээс ардын уламжлалт гар урлалын төрөлд 22%, эх, хэл аман уламжлалт төрөлд -11%, Ардын язгуур урлаг-29% , Уламжлалт зан үйл, баяр наадам-13%, мэдлэг зан үйлийн -25% аймгийн бүртгэл мэдээдллийн санд бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 1946 онд байгуулагдсан Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит Төв номын сан, 1948 онд байгуулагдсан Хөгжимт драмын театр, 1950 онд байгуулагдсан аймгийн Музей, 1948 онд байгуулагдсан Халхгол сумын Ялалт музей болон 13 сумын Соёлын төв нийт 17 төрийн үйлчилгээний байгууллага, соёл, урлагийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэн ажиллаж байна.

Тодруулбал: Сумдын соёлын төвүүдэд нийт-65, аймгийн музейд-24, аймгийн төв номын санд-18, Хөгжимд драмын театрт-79, Ялалт музейд-11 нийтдээ 179 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс соёл, урлагийн тусгай мэргэжил шаардсан ажлын байранд нийт 148 уран бүтээлч, соёлын ажилтан байхаас 2017 оны 10 сарын байдлаар 98 ажиллагсад байгаа нь мэргэжлийн боловсон хүчний хангалт 66.2 хувьтай байна

Мөн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуульд дуу хөгжмийн багш дутагдалтай байна.

Аймгийн соёл, урлагийн салбарт ажиллаж байгаа албан хаагчдын цалин, нийгмийн хангаж өнөөгийн бодит түвшинд бусад салбартай харьцуулбал харьцангуй сул байна.

Нийт албан хаагчдын 90-дээш хувь нь зээлийн дарамтанд ажиллаж амьдарч байна.

Матад, Гурван загал сумдын Соёлын төвүүдийн барилга ашиглалтын хугацаа дуусаж үйл ажиллагааг явуулахыг хориглосон Улсын байцаагчийн дүгнэлт гарч 2016 оноос эхлэн дээрх сумдын иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээ тасалдаад байна.

II БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

2.1. Хөтөлбөрийн зорилго

Орон нутгийн хөгжилд, аймгийн соёл урлагийн мэргэжлийн байгууллагуудын оруулах хувь нэмэр, үр ашгийг өсгөх, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилготой болно.

2.2. Хөтөлбөрийн зорилт

2.2.1. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ, СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ХҮРГЭХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ;

2.1.2. ҮНДЭСНИЙ СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛУУЛАХ, БАЯЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХЭД СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА НЬ ТӨР, ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ;

2.2.3. ДЭЛХИЙН БОЛОН ҮНДЭСНИЙ СОНГОДОГ, ШИЛДЭГ УРЛАГИЙН БҮТЭЭЛ, СОЁЛЫН БИЕТ ӨВ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ИРГЭД, ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ;

2.2.4. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД СОЁЛ, УРЛАГИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Зорилт 1: Мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:

3.1.1. Дорнод аймгаар овоглосон уран бүтээлчид, соёлын ажилтнуудын залгамж холбоог бэхжүүлж, орон нутгийн соёлын мэргэжилтнүүдийн хүний нөөцийг чадавхжуулах;

3.1.2. Музей, орон нутгийн судлах танхим, номын сангийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүүхэд багачуудын танин мэдэх төв болгох;

3.1.3. Иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагуудын гадаад, дотоод орчин, нөхцөл, хөгжим, бусад хэрэглэгдэхүүнийг сайжруулах;

3.1.4. Соёл урлагийн байгууллагуудын уран бүтээл, соёлын бүтээлүүдийн цахим мэдээллийн сан, архивтай болох;

Зорилт 2: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах, баяжуулан хөгжүүлэхэд соёлын байгууллага нь төр, олон нийтийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах зорилтын хүрээнд:

3.2.1. Монгол хэл бичгийн соёлыг олон нийтэд танилуулах, хүүхэд залууст уламжлуулах, хэрэглээг нь өргөжүүлэх, сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

3.2.2. Хүүхэд залуучуудад, гэр бүлийн хүмүүжлийг дээдлэн, угийн бичиг, удмын судрыг өвлүүлэн уламжлуулах, аймаг орон нутгийн түүхийг таниулж, эх оронч үндэсний соёлоор бахархах үзлийг гэр бүл, соёл, боловсролын байгууллагаар дамжуулан төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх;

3.2.3. Олон улс, аймгийн хэмжээнд уламжлал болсон барга, буриад, үзэмчин ястны өв соёлыг түгээх, өвлүүлэн үлдээх Алтаргана, Баргажин, Алтан-дөрөө, “Бид Дорнодын хүүхдүүд” найрал дууны наадам зэрэг урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд залуусыг өргөнөөр оролцуулах;

3.2.4. Иргэдийн соёлын биет бус өвийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, соёлын үнэт зүйлийг бүтээн туурвигч, хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг идэвхжүүлэн дэмжих;

Зорилт 3: Дэлхийн болон үндэсний сонгодог, шилдэг урлагийн бүтээл, соёлын биет өв, үнэт зүйлсийг иргэд, олон нийтэд таниулах зорилтын хүрээнд:

3.3.1. Аймгийн Хөгжимт драмын театрын симфони найрал хөгжмийн болон шилдэг уран бүтээлийн тоглолтын урын санг нэмэгдүүлэх;

3.3.2. Дэлхийн болон үндэсний сонгодог, урын сангийн шилдэг бүтээлийг орон нутаг, алслагдсан хөдөөгийн хүн амд хүргэх;

3.3.3. Соёл урлагийн байгууллагад үндэсний уламжлалт болон орчин үеийн технологи, дизайныг нэвтрүүлж, инноваци хөгжүүлэхэд иргэн, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;

3.3.4. Соёлын биет өвийг хамгаалж, сэргээн засварлах, үнэт зүйлсийг иргэд, олон нийтэд таниулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болгох;

Зорилт 4: Орон нутгийн хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Мэргэжлийн урлагийн байгууллагууд, сумын Соёлын төвүүд нь өөр өөрийн онцлог шинж чанарыг хадгалсан мэргэжлийн түвшинд өрсөлдөхүйц үндэсний соёлын агуулга бүхий нэрийн бүтээгдэхүүн /бренд/-тэй, тоглолтын хөтөлбөрүүдтэй болж түүнийгээ аялал жуулчлалын эргэлтэд оруулах;

3.4.2. Монгол ардын уламжлалт болон дахин давтагдашгүй үндэсний уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах “Үл бүдгэрэх-Их өв соёл” төслийг хэрэгжүүлэх;

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Дунд хугацаанд үнэлэх түвшин 2019 он	Зорилт от түвшин 2021 он	Хэрэгжүүлэх байгууллагууд
Зорилт 1: Мэргэжлийн байгууллагуудыг чадавхижуулах, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:						
1.1	Орон нутгийн онцлогт тулгуурласан, хөтөлбөр хэрэгжүүлэх 2018-2021 оны төлөвлөгөө ажлын төлөвлөгөө, хүрэх үр дүнгээ тодорхойлсон байгууллага	тоо	0	17	17	Соёл урлагийн байгууллагууд
1.2	Соёл, урлагийн салбарт ажиллагсдын мэргэжилтэй ажиллагсад	хувь	80	90	100	Төрийн байгууллагууд
1.3	Нийтийн номын сангийн байнгын уншигчид	100 хүн тутамд ногдох тоо	112	268	370	аймгийн Төв номын сан, сумын Соёлын төвийн нийтийн номын сан
1.4	Музейн үзэгчид	100 хүн тутамд ногдох тоо	18	32	53	аймгийн Төв музей, Халхгол сумын Ялалт музей, сумын Соёлын төвийн Орон нутгийн судлах танхим
1.5	Шинэ барилга, байгууламжтай болсон соёлын байгууллага	тоо		1	3	БСУГ
Зорилт 2: Үндэсний соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах, баяжуулан хөгжүүлэхэд соёлын байгууллага нь төр, олон нийтийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах зорилтын хүрээнд:						
2.1	Угийн бичгийг хөтөлдөг өрх	хувь	60	80	100	аймгийн Төв номын сан, сумын Соёлын төвүүд
2.2	Зохион байгуулсан соёл урлагийн арга хэмжээ /үзэсгэлэн, өдөрлөг, наадам/	тоо		8	16	БСУГ
2.3	Монгол судлал, соёл урлагын салбарын эрдэм шинжилгээ судалгааны бага хурал	тоо		4	8	БСУГ
Зорилт 3: Дэлхийн болон үндэсний сонгодог, шилдэг соёл урлагийн бүтээл, соёлын биет өв, үнэт зүйлсийг иргэд, олон нийтэд таниулах зорилтын хүрээнд:						
3.1	Мэргэжлийн урлагийн тоглолт үзэгчдийн тоо	1000 хүн тутамд		200	300	Аймгийн Хөгжимт драмын театр
3.2	Хүүхэд, залууст урлаг, соёлын боловсрол олгодог	тоо	3	7	10	БСУГ

	клуб, дугуйлан					
Зорилт 4: Орон нутгийн хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:						
4.1	Орон нутгийн онцлогтой урлаг, соёлын нэрийн бүтээгдэхүүн	тоо		5	14	Аймгийн Хөгжимт драмын театр 13 сум
4.2	Хэрэгжүүлсэн төсөл	тоо	1	3	5	БСУГ
4.3	Аймаг, орон нутгаа танилцуулах бүтээлийн сан	нэр төрөл, тоо		3	5	БСУГ
4.4	Бусад улс, оронд зохион байгуулсан урлаг, соёлын арга хэмжээ	тоо	1	2	4	Аймгийн Хөгжимт драмын театр

3.4.3. Дорнод аймгаа сурталчлан таниулах орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёл, ёс уламжлал, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан ерөөл магтаал, дуу, танилцуулга сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэх;

3.4.4. Хөрш орнуудтай соёлын салбарт харилцан үр ашигтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, монгол үндэстэн, аймаг орон нутгийн соёл урлаг, түүхийг сурталчлах Дорнод аймгийн соёлын өдөрлөгийг зохион байгуулах;

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Хөтөлбөрийн хугацаа: Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

Аймгийн соёл урлагийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж, үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Олон улсын байгууллага, хандивлагч орны хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- Бусад эх үүсвэр

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний

санал санаачлагыг дэмжин хамтран ажиллах, хөтөлбөрийн тайланг жил бүр гаргах, олон нийтэд мэдээлэх үүргийг, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар хариуцна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

6.2.1. Аймгийн Хөгжимт драмын театр, аймгийн Төв номын сан, аймгийн Төв музей, Халхгол сумын Ялалт музей, сумын Соёлын төвүүд нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгуулах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

6.2.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож, дэмжиж хамтран ажиллана.

6.2.3. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага нь Монгол улс нэгдэн орсон дэлхийн соёлын Конвенц, Монгол улсын соёлын талаарх бодлого, бодлогын баримт бичгүүд болон энэхүү хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулна.

6.2.4. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу жил бүрийн 10 дугаар сарын 01-нд багтаан, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах хэлбэрээр зохион байгуулна.

6.3.1. Хөтөлбөр хэрэгжилтийн жил бүрийн тайланд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.

6.3.2. Хөтөлбөрийн дунд хугацааны зорилтот түвшинг 2019 онд, хөтөлбөрийн зорилтот түвшинд хүрсэн байдалд 2021 онд тус бүр хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэнэ.

---oOo---

ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

- Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай Конвенц, Монгол улс энэхүү конвенцэд 1990 оны 2-р сарын 2-нд нэгдэн орсон
- "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай" конвенц, Монгол улс энэхүү конвенцэд 1991 оны 5 сарын 23-нд нэгдэн орсон.
- Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенц, Монгол Улс 2007 онд нэгдэн орсон.
- “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” Конвенц Монгол Улс 2007 онд нэгдэн орсон.
- **Монгол улсын үндсэн хуулиас:**

“Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхаа уламжлалыг нандигнан өвлөж, -эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэн ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.
- “Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан.
- Монгол улсын Соёлын тухай хууль,
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль,
- Номын сангийн тухай хууль,
- “Соёлын баримтат өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөр
- Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, 2030 он хүртэлх төсөөлөл”,
- **ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

2.2.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдэд уламжлалт зан заншил, өв соёл, түүхээрээ бахархдаг, эх оронч сэтгэлгээ, үнэт зүйлтэй болгон төлөвшүүлэх тэдний хөгжлийг дэмжсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

2.2.11. Боловсрол, соёл урлагийн байгууллагын бүх шатны боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлэх, тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодод сургах, багш, мэргэжилтнүүдийг гэрээгээр урьж ажиллуулах, туршлага судлах, мэргэжлийн чиглэлээр бүс, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.2.21. Аймгийн музейн болон соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийг шинээр барих, засварлах, зарим сумдад орон нутаг судлах танхим бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.2.20. Иргэдэд мэргэжлийн урлагийн шилдэг бүтээл, соёл урлагийн чанартай үйлчилгээг хүргэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

2.2.22. Угсаатны урлаг соёлын “Алтан дөрөө”, “Алтаргана”, “Хатагин”, “Баргажин”, “Тоонот нютаг”, “Эв модны наадам” зэрэг томоохон арга хэмжээг олон улсын аялал жуулчлалтай холбож хөгжүүлнэ.

2.2.23. Боловсрол, соёл, спортын байгууллага бүр бүтээмж, өрсөлдөх чадвараа тасралтгүй нэмэгдүүлж, бие даан хөгжих “Дорнод аймгийн Хөгжлийн хөтөлбөр”-тэй уялдсан урт хугацааны хөгжлийн хөтөлбөртэй болж, хэрэгжилтийг олон нийтэд танилцуулж ажиллана.

➤ **Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл:**

Аймгийн соёл урлагийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж, үе шаттай хэрэгжүүлнэ.